

ХАВСРАЛТ А

**ЗЭВСГИЙН ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ОЛОН
УЛСЫН ГЭРЭЭГ ТҮГЭЭМЭЛЖҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА**

ANNEX A

ATT UNIVERSALIZATION TOOLKIT

ХАВСРАЛТ А

ЗЭВСГИЙН ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ ТҮГЭЭМЭЛЖҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА

1. Хэнд зориулсан гарын авлага вэ?.....	2
2. Зэвсгийн худалдааг зохицуулах гэрээ гэж юу вэ?.....	2
2.1 Гэрээ батлагдсан шалтгаан нь юу вэ?.....	2
2.2 Гэрээ батлагдсан ба хүчин төгөлдөр болсон нь.....	3
2.3 Хичнээн тооны улс ЗХЗГ-нд нэгдсэн бэ?.....	3
3. ЗХЗГ-ийг түгээмэлжүүлэх нь яагаад чухал вэ?.....	3
4. Гэрээнд нэгдсэнээр ямар ач холбогдолтой вэ?.....	4
4.1 Ил тод байдал.....	4
4.2 Энх тайван ба аюулгүй байдал.....	5
4.2.1 ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ.....	5
4.2.2 ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ.....	5
4.2.3 БҮС НУТГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ.....	6
4.3 Хүний эрх.....	6
4.4 Тогтвортой хөгжил.....	6
4.5 Худалдааг зохицуулах ба Худалдааны стандартыг сайжруулах нь.....	7
4.6 Бусад байгууллагатай хавсарсан нөлөө.....	7
5. Гэрээнд нэгдсэнээр улс орнууд ямар сорилттой тулгарч байна вэ?.....	7
6. Түгээмэл асуудаг асуулт.....	8
6.1 Энэ гэрээ олон улсын зэвсгийн худалдаанд ямар өөрчлөлт авчрах вэ?.....	8
6.2 Гэрээнд хараахан нэгдээгүй орнууд ямар байдалтай байна вэ?.....	9
6.3 Гэрээний хамрах хүрээ нь аль хүртэл вэ?.....	9
6.3.1 ЗХЗГ нь ямар хэлбэрийн зэвсэгүүдэд үйлчлэх вэ?.....	9
6.3.2 ЗХЗГ нь ямар хэлбэрийн арилжаанд үйлчлэх вэ?.....	10
6.4 Оролцогч улсууд амлалтаа мөрдөнө гэдэгт хэрхэн итгэлтэй байж болох вэ?.....	10
6.5 Гэрээний дагуу оролцогч улсууд зэвсэг импортлохыг хориглох уу?.....	11
6.6 Гэрээний хэрэгжилтэд иргэний нийгэм ямар үүрэгтэй вэ?.....	11

1. Гарын авлагыг хэнд зориулж боловсруулсан бэ?

Түгээмэлжүүлэх гарын авлагыг “Түгээмэлжүүлэх ажлын хэсэг(TAX)” боловсруулсан юм. Уг гарын авлага нь ЗХЗГ-г түгээмэлжүүлэхийг хүсч буй оролцогч улс, ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар, иргэний нийгэм зэрэгт туслах зорилгоор боловсруулав. Гарын авлага нь CSP4-н шийдвэр болон санал болгосон зүйлс төдийгүй ЗХЗГ-ний ажлын хэсгийн хурлын явцад явагдсан оролцогч улсуудын хэлэлцүүлэг болон санал солилцооны үед хуваалцсан мэдээлэл болон туршлага дээр үндэслэсэн болно.

2. ЗХЗГ гэж юу вэ?

Зэвсгийн худалдааг зохицуулах гэрээ (ЗХЗГ) гэдэг нь ердийн зэвсгийг хууль бусаар худалдах болон хууль бусаар зувчуулахаас сэргийлж, таслан зогсоохын тулд олон улсын хэмжээнд хамгийн өндөр түвшний зэвсгийн худалдааны хяналтын стандартыг тогтоох, үүнд үндэслэн ердийн зэвсгийн худалдааг зохицуулж буй олон улсын гэрээ юм.

Гэрээний 1-р зүйлд зааснаар ЗХЗГ-ний агуулга нь

- Ердийн зэвсгийн олон худалдааны зохицуулалтыг сайжруулах, эсхүл олон улсын нийтлэг стандартын аль болох дээд зэргийн зохицуулалтыг бий болгох
- Ердийн зэвсгийн хууль бус худалдаанаас сэргийлэх болон таслан зогсоох, тэдгээрийг хууль бусаар зувчуулахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Дээрх үзэл санаанд суурилан ЗХЗГ-ний үндсэн зорилго нь доорхитой адил байна.

- Олон улсын болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал ба тогтвортой байдалд хувь нэмэр оруулах
- Хүн төрөлхтний зовлон зүдгүүрийг (human suffering) багасгах
- Ердийн зэвсгийн олон улсын худалдаанд оролцогч улсын хамтын ажиллагаа, ил тод байдал, үүрэг хариуцлагыг дээшлүүлж, түүгээрээ оролцогч улс хоорондын итгэлцлийг бэхжүүлэх

“Энэ нь олон улсын зэвсгийн худалдаанд ил тод байдал, хариуцлага, эгэх хариуцлагыг дэмжиж бидний хамтын хичээл зүтгэлд шинэ хуудас нээснийг харуулав” – Бань Ги Мүн 1

ЗХЗГ нь олон улсын болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, тогтвортой байдалд хувь нэмэр оруулж, хүний зовлон шаналлыг багасгаж, олон улсын хамтын ажиллагаа, ил тод байдал, улсын хариуцлагыг дэмжинэ.

2.1 Гэрээ батлагдсан шалтгаан нь юу вэ?

ЗХЗГ нь НҮБ-ын гишүүн орнууд дараахь зүйлийг хүлээн зөвшөөрсөн тул батлагдсан болно.

“Ердийн зэвсгийг экспортлох, импортлох мөн шилжүүлэхэд тавигдах олон улсын түгээмэл стандарт байхгүй байгаа нь мөргөлдөөн, энгийн иргэдийн албадан шилжилт, гэмт хэрэг, терроризмд хувь нэмэр болсноор энх тайван, эв найрамдал, амар тайван, аюулгүй байдал,

тогтвортой байдал мөн тогтвортой хөгжлийг сааруулах хүчин зүйл болж байна” (Шийдвэр 61/89-н 9-рт 『 Зэвсгийн худалдааг зохицуулах гэрээний тухай: Ердийн зэвсгийг импортлох экспортлох, шилжүүлэх тухай олон улсын нийтлэг стандартыг боловсруулах』) болохыг тодорхойлсон байдаг).

2.2 Гэрээ батлагдсан ба хүчин төгөлдөр болсон нь

ЗХЗГ нь 2013 оны 4 дүгээр сарын 2 өдөр НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганы шийдвэрээр батлагдсан ба 2014 оны 12 дугаар сарын 24 өдрөөс хүчин төгөлдөр болж, ердийн зэвсгийн худалдааны талаархи эрхзүйн чадамжтай олон улсын анхны гэрээ болсон.

2.3 Хэдэн улс ЗХЗГ-нд нэгдэн орсон бэ?

Өнөөг хүртэл 100 гаруй улс ЗХЗГ-нд нэгдэн орсон ба зарим улс нь гарын үсэг зурсан боловч хараахан эцэслэн батлаагүй байна.

Бүс нутаг тус бүрээр нэгдэн орсон байдал, мөн улс тус бүрээр ЗХЗГ-нд нэгдэн орсон статусын талаарх сүүлийн үеийн мэдээллийг ЗХЗГ-ний вебсайт: <https://www.thearmstradetreaty.org/treaty-status.html?templateId=209883>-аас шалган үзэх боломжтой.

3. ЗХЗГ-ний түгээмэлжүүлэлт(universalization) яагаад чухал вэ?

Гэрээний 17.4-р зүйлд оролцогч улсын бага хуралд зайлшгүй анхаарах ёстой зүйлсийг тодорхойлсон байна. 17.4-р зүйлийн (б)-д оролцогч улсын бага хурлаар “энэхүү гэрээний хэрэгжилт болон үйл ажиллагаа, нэг ялангуяа гэрээг түгээмэлжүүлэхтэй холбоотой зөвлөмжийг хэлэлцэж батлах” гэж тодорхой заасан байдаг. Ийнхүү гэрээнд гэрээг түгээмэлжүүлэхийг дэмжих нь оролцогч улсын бага хурлаас анхаарах ёстой ач холбогдол бүхий чухал хүчин зүйл гэж зохицуулсан байна.

Бодит байдалд ч гэрээний түгээмэлжүүлэлт нь гэрээнд оролцогч улсын 3 дугаар бага хурлаас “гэрээний түгээмэлжүүлэлтийн ажлын хэсэг(WGTU)” байгуулж, ЗХЗГ-ний түгээмэлжүүлэлтийг дээшлүүлэх ба “тусгай үйл ажиллагаа ба зорилтот зүйлийг хөгжүүлэх мөн гэрээг түгээмэлжүүлэх үзэл санааг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрхийг олгох” хэмжээний гэрээ дотроо нэн тэргүүний зүйл гэж онцолж байгаа юм. ЗХЗГ-ний түгээмэлжүүлэлт гэдэгт аль болох олон оролцогч улсууд оролцохуйцаар гэрээний гишүүн орнуудын тоог нэмэгдүүлэх нь ч багтана. Түгээмэлжүүлэх гэдэг ойлголт нь гэрээний үндсэн бүлэгт томъёолоогүй боловч гэрээний эрхийг өргөжүүлнэ гэсэн утгаар тайлбарлаж болно. Аль болох олон оролцогч улсыг ЗХЗГ-нд оролцуулахын чухал байгаагийн шалтгаан нь тодорхой хэмжээнд хангалттай тооны орнууд оролцож байж олон улсын журмын систем ажилладаг оршино. Цөөн тооны сайн санаат экспортын компаниуд зэвсгийг шилжүүлэхтэй холбоотой эрсдлийг үнэлнэ гэдэг нь утга учир багатай юм. Хяналт хэрэгжихгүй

байгаа газарт хууль бус зэвсэг урьдын хэвээр нийлүүлэгдсээр байх болно. Бодитоор бүх орон оролцогч улс болсон гэрээ, хэлэлцээр тун цөөн тооноос хэтрэхгүй. Тэгвэл ЗХЗГ-ний үүднээс “түгээмэлжүүлэлт”-д хүрэхийн тулд хичнээн тооны, эсвэл ямар төрлийн улс орнууд хэрэгтэй болох вэ? 2018 оны 6 дугаар сард ЗХЗГ нарийн бичгийн дарга нарын газар нь зэвсэг экспортлогч болон импортлогч тэргүүлэх 50 улс дотроос ЗХЗГ-нд элсэн орсон орны тоог шинжлэж үзсэн. Үр дүнгээс үзвэл дийлэнх тэргүүлэх экспортлогч орнууд, өөрөөр хэлбэл дэлхийн зэвсгийн экспортын 73 хувийг хангадаг улс гэрээний оролцдог болон гарын үсэг зурж нэгдэн орсон байсан бөгөөд дэлхий даяархи зэвсгийн экспортын 71 хувийг эдгээр орнууд гүйцэтгэж байсан юм. Оролцогч улс болон гарын үсэг зурсан улс болж нэгдэн орсон импортоор тэргүүлэгч орнууд нь 53 хувьтай байсан ба тэд дэлхийн нийт зэвсгийн импортын 36 хувийг эзэлж байв. Түгээмэлжүүлэхийн тулд хийх шаардлагатай ажил урьдын адил их байна.

Энэ гэрээний эргэлтийн мөч нь гэрээний гишүүний хувьд гэрээг хэрэгжүүлдэг улс орон хангалттай олширох мөч бөгөөд өөрөөр хэлбэл оролцогч улс биш байлаа ч гэрээний зарчмыг дагаж мөрдөх нь ердийн үзэгдэл болох мөч гэж хэлж болно. Түгээмэлжүүлэлтийн гол нөхцөл нь оролцогч улсын тоондоо ч бус ерөнхий хандлагын асуудал байж ч болох юм.

4. Гэрээнд нэгдсэнээр үүсэх давуу тал нь юу вэ?

Зэвсгийн худалдааг зохицуулах гэрээний 1-р зүйлд тодорхойлсончлон, ЗХЗГ-ний зорилго нь эерэг үр дүнг авчрах бөгөөд энэ нь гэрээний туйлын зорилгод ч тусгасан байдаг. Гэрээнд нэгдэнэ гэдэг нь ЗХЗГ-ний заалтыг хэрэгжүүлдэг олон улсын нийгэм, өөрөөр хэлбэл 1-р зүйлд дурьдсан зорилгын төлөө сайн зохицуулалттай ердийн зэвсгийн худалдаа явуулдаг улсуудын хамтын нийгэмлэгийн гишүүн болно гэсэн утгатай юм.

4.1 Ил тод байдал

ЗХЗГ нь зэвсэг шилжүүлэх талаар хэрэгжилтийн тайлан, жилийн тайлангаар дамжуулан сайн дураараа мэдээллээ солилцох төдийгүй ил тод байдлыг дээшлүүлнэ. ЗХЗГ нь оролцогч улс бүр хоёр талын болон олон талын түвшинд дараах зүйлст тус нэмэр болох санал солилцох ил тод сувгийг нээх боломжоор хангана.

- Харилцан ашиг сонирхолоо тодорхойлох
- Итгэлцэлийг бэхжүүлэх
- Худалдааны стандартыг сайжруулахтай холбоотой хамтын ажиллагаа
- Гэрээнд заасан үүргийг биелүүлсэн эсэхийн үнэлгээг идэвхжүүлэх
- Зэвсэг шилжүүлэхтэй холбоотой чиг хандлагыг тандах
- Оролцогч улс гэрээг хэрхэн хэрэгжүүлэх ёстой талаар хандлагыг олгох болон шилдэг жишээг тандах
- Олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх
- Дэмжлэг шаардлагатай улс орон болон санхүүжилт арвинтай улс орныг холбох

Нөгөө талаар, аль ч улс олон улсын аюулгүй байдалд санаа зовниж байдаг. ЗХЗГ нь энэхүү нөхцлийг харгалзаж, арилжааны хувьд эмзэг эсвэл улсын аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг жилийн тайланд оруулахгүй байх эсвэл гадагшаа ил болгохын оронд гишүүн орнуудад л ил болгож болох тайланг тусгайлан гаргахаар болж байгаа юм.

4.2 Энхтайван ба аюулгүй байдал

4.2.1 ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ЗХЗГ-ний удиртгалд тодорхойлсончлон, хууль бус бөгөөд зохицуулалтгүй ердийн зэвсгийн худалдаа нь аюулгүй байдал, нийгэм, эдийн засаг болон хүмүүнлэгийн хувьд сөрөг үр дагавар авчирдаг.

Зэвсэг ашиглах боломж болон буруу хэрэглээ нь зөрчил байгаа эсэхээс үл хамаарч хүний аюулгүй байдалд шууд болон шууд бусаар нөлөө үзүүлдэг. Энэ нь хүний амины гарз, хохиролын шалтгаан болох төдийгүй энгийн иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээ боловсрол хүнсний аюулгүй байдлыг хүртэх боломжийг хязгаарлах, хохирогч болон түүний гэр бүлд сэтгэлзүйн болон эдийн засгийн хувьд сөрөг үр дагавар авчиргах шалтгаан болж болно.

Хууль бус зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсгийг хадгалах, худалдаалах нь зэвсэгт мөргөлдөөнийг удаашруулах шалтгаан болж ч болох бөгөөд мөргөлдөөн дууссны дараа ч гэсэн удаан хугацаанд энгийн иргэдэд аюул учруулж болзошгүй.

ЗХЗГ нь хүний аюулгүй байдлыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг. ЗХЗГ-ний 6-р зүйлийн 3-т “Төрлөөр устгах, хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг, 1949 оны Женевийн конвенцийг санаатайгаар зөрчсөн, энгийн иргэдийн эсрэг болон тэдгээрийн хамгаалагдсан байгууламжид халдсан, тухайн улс нэгдэн орсон олон улсын гэрээнд тодорхойлсон бусад төрлийн дайны гэмт хэрэг үйлдэхэд ашиглагдаж болзошгүйг зөвшөөрөл олгох үед мэдэж байсан бол” оролцогч улс ердийн зэвсгийн ямар ч төрлийн шилжүүлэх зөвшөөрлийг олгохгүй байхаар урьдчилан сэргийлдэг.

4.2.2 ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Гэрээний үүрэг нь ашиглаж болохуйц зэвсгийг хариуцлага бүхий эцсийн хэрэглэгчийн эзэмшилд үлдээж, гэмт хэргийн бүлэглэлийг зэвсгээр хангах явдлыг бууруулах явдал юм. Хууль бус зэвсэг нь оршин буй гэдэг утгаараа аливаа улсын аюулгүй байдал, цэрэг болон хууль хэрэгжүүлэгч холбогдох хүмүүс дотоодын аюулгүй байдлаа үр дүнтэйгээр хангахад тулгарч байгаа сорилт билээ.

Гэрээг дагаж мөрдөх нь өнөөгийн улсын тогтолцоонд оршиж буй сул талаа(гар) танихад тус болно. Өөрөөр хэлбэл улс орнууд сул талаа дүгнэн шинжилж, шаардлагатай тохиолдолд санхүүгийн болон техникийн дэмжлэг хүссэнээр сул талаа багасгаж, үндэсний зэвсгийн хяналтын хүчтэй иж бүрэн тогтолцоог хангаж чадах юм.

Энэхүү гэрээнд тухайн оролцогч улс ердийн зэвсгийг өөрийн өмчлөл дор байлгана гэж үзсэн тохиолдолд, тухайн улс өөрөө ашиглах зорилгоор ердийн зэвсгийн тээвэрлэлтийг шууд гүйцэтгэж буй, эсвэл бусдаар гүйцэтгүүлж буй олон улсын тээвэрт энэ гэрээ үйлчлэхгүй гэдгийг тодорхой заасан байдаг. Тиймээс байршиж буй цэргийн баазад зэвсэг техник шилжүүлэх нь энэхүү гэрээнд заасан “шилжүүлэх” гэсэнд хамаарахгүй бөгөөд, асуудал бүхий үүрэг гүйцэтгэсний дараа зэвсгийг дахин шилжүүлээгүй бол (мөн үлдээгээгүй бол) эрсдлийн үнэлгээ шаардлагагүй.

4.2.3 БҮС НУТГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ЗХЗГ нь хууль бус зэвсэг болон галт хэрэгсэл/ зэр зэвсэг хил давахаас сэргийлэхэд хувь нэмэр оруулах бөгөөд эцсийн үр дүндээ бүс нутгийн аюулгүй байдлыг тогтворгүйжүүлдэг ердийн зэвсгийн нөлөөллийг бууруулах болно.

Мөн түүнчлэн оролцогч улсуудын хамтын ажиллагаа, ил тод байдал, хариуцлагатай үйлдлийг дээшлүүлж, зувчуулах болон хууль бус худалдахаас сэргийлэх зорилготой бүс нутгийн хамтын ажиллагааны өнөөгийн тогтолцоог бэхжүүлэхийн төлөөх бүтцээр хангана.

4.3 Хүний эрх

ЗХЗГ-ний оролцогч улс нь зэвсэг шилжүүлэхийг шийдэхдээ гэрээний 6 болон 7-р зүйлийг оролцуулан олон улсын хүний эрхийн хууль болон олон улсын хүмүүнлэгийн хуулийг голчлон харгалзаж үзэх шаардлагатай. 7-р зүйлийн дагуу оролцогч улс нь ЗХЗГ-ний 2 (1)-р зүйл, 3-р зүйл, 4-р зүйлийн дагуу үйлчилж буй хамгийн бага хэмжээний ердийн зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсэг, түүний эд анги болон бүрэлдэхүүн хэсгийг шилжүүлэх зөвшөөрөл олгохын өмнө заавал эрсдэлийн үнэлгээний стандартыг нэвтрүүлэх ёстой ба экспортлогдож байгаа зэвсэг нь олон улсын хүний эрхийн хууль эсвэл олон улсын хүмүүнлэгийн хуулийг ноцтойгоор зөрчиж байгаа эсвэл түүнийг түргэсгэж болохуйц ноцтой эрсдэлтэй байх тохиолдолд холбогдох экспортоос татгалзах ёстой.

ЗХЗГ нь олон улсын хүний эрхийн хуулийг эрсдлийн үнэлгээний процессд нэвтрүүлснээр ердийн зэвсгийн худалдаанд олон улсын хүний эрхийн хуулинд заасан стандарт мөрдөгдөж хэрэгжиж, үйлчилж байхуйцаар дэмжиж байгаа бөгөөд эцсийн үр дүндээ олон улсын хүний эрхийн хуулийг бэхжүүлэн сайжруулж байна.

Мөн түүнчлэн энэхүү гэрээ нь эрсдлийн үнэлгээний стандартад хүйст суурилсан хүчирхийлэлтэй холбоотой эгзэгтэй асуудлыг маш тодорхой онцолж өгсөнөөр эмэгтэйчүүд болон хүүхдэд учрах зэвсгийн мөргөлдөөн, зэвсгийн хүчирхийллийн сөрөг нөлөөллийг онцлон тэмдэглэсэн. (7-р зүйлийн 4-ийг харах)

4.4 Тогтвортой хөгжил

ЗХЗГ нь тогтвортой хөгжлийн зорилтууд (SDGs) 16.3-р зүйл (2030 он хүртэл “хууль бус хөрөнгө ба зэвсэг оруулахыг өргөн хүрээтэйгээр бууруулах), 5.2-р зүйл (эмэгтэйчүүд ба эмэгтэй хүүхдийн талаарх бүх төрлийн хүчирхийллийг халах), 11-р зүйл (хүртээмжтэй, найдвартай, нөхөн сэргээгддэг бөгөөд тогтвортой хот болон амьдралын орчинг бүрдүүлэх)-д заасан зорилгыг биелүүлэхэд хувь нэмэр оруулна.

ЗХЗГ хэрэгжилт нь тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхийг дэмжиж, сайжруулахад “хэрхэн” тус болж чадах тухайг харгалзан үзэх нь ЗХЗГ-ний бүх ажлын хэсгийн анхаарал тавих ёстой салбар нийтийн эгзэгтэй асуудал юм.

Ил тод байдал, мэдээлэл хадгалах ба илтгэх, мэдээлэл хуваалцах, олон улсын тусламж гэх мэтийн тухай ЗХЗГ-ний заалт нь тогтвортой хөгжлийн зорилгын нарийвчилсан зорилт болох 16.а зүйлийн хэрэгжилтэд хувь нэмэр болно. ТХЗ-ын нарийвчилсан зорилт болох 16.1-р зүйлд “хүчирхийллээс сэргийлэх болон терроризм ба гэмт хэргээс ангижрах зорилгоор, нэн ялангуяа хөгжиж буй орнуудад бүх түвшний чадавхийг бэхжүүлэхийн тулд олон улсын хамтын ажиллагаа мэтээр дамжуулан холбогдох улсын байгууллагыг бэхжүүлэх”-эд дэмжлэг үзүүлнэ.

4.5 Худалдааны зохицуулалт болон худалдааны стандартыг сайжруулах

ЗХЗГ нь олон улсын стандартыг бий болгох, эрсдлийн үнэлгээний стандартыг бүх л шилжүүлэлтэд ижил тэгш үйлчилдэг болгохыг зорьж буй юм. ЗХЗГ нь олон улсын худалдааны стандарт болон дагаж мөрдөх тогтолцоог бий болгон зэвсгийн худалдаанд зориулсан шударга өрсөлдөөний нөхцөл бүрдүүлэхэд туслах болно.

Салбарын оролцогчид дэмжиж буйгаа илэрхийлсэн нь ч бас ийм шалтгаантай юм. Тэд урьд өмнөх экспортлогч олон орнуудад үйлчилж байгаа зохицуулалт стандартыг шинээр гарч ирж буй үйлдвэрлэгчид болон экспортлогч компаниудад ч бас адилхан үйлчилж байх боломжит хэрэгсэл гэж үзэж байна.

Компаниуд ч бас гадаад имиждээ өмнөхөөс илүү анхаарах болсон бөгөөд худалдаанд хүний аюулгүй байдлыг голчилсон хандлага бага багаар улам нэмэгдсээр байна. ЗХЗГ нь энэхүү хандлагыг бэхжүүлэх боломжийг олгож байна.

4.6 Бусад байгууллагатай харилцан үүсэх синержи үр өгөөж

ЗХЗГ нь бага оврын зэвсэг ба галт зэвсгийн протоколын талаарх НҮБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө(Programme of Action on Small Arms and the Firearms Protocol) гэх мэтийн олон улсын мөн бүс нутгийн түвшинд зэвсгийг хянах байгууллагуудыг дэмжиж, харилцан туслана.

5. Гэрээнд элсэн ороход улс орнуудад ямар сорилт, даалгавар тулгардаг вэ?

Доор дурдсан зүйлс нь “Гэрээг түгээмэлжүүлэх ажлын хэсгийн хамтарсан төлөөллөөс тодорхойлон гаргасан бөгөөд CSP4 бэлтгэл хурлын ажлын төлөвлөгөө the [Work Plan for the CSP4 Preparatory Meetings](#) (see Annex A, ATT/CSP4.WGTU/2018/CHAIR/249/M1.WorkPlan):”-нд

хавсаргасан гэрээний түгээмэлжүүлэлтэд учирч буй сорилт даалгавруудын жагсаалтын хэсэг нь юм.

- 1 Гэрээг батлахтай холбоотой улс төрийн ойлголтыг бий болгох
- 2 Засгийн газар болон парламентын зорилтод жагсаалтад ЗХЗГ-г зорилт оруулах
- 3 ЗХЗГ-г ойлгох, мөн ЗХЗГ-ний талаарх тээнэгэлзсэн хандлагыг багасгах
 - 3.1 Гэрээний эрмэлзэл болон зорилгын талаарх буруу ойлголт
 - 3.2 Ялангуяа холбогдох байгууллагын гаргаж буй тээнэгэлзсэн хандлага
- 4 Дотоодын улс төрийн болон аюулгүй байдлын нөхцөл байдал
 - 4.1 Парламентын сонгууль
 - 4.2 Буутай холбоотой лобби бүлэг
 - 4.3 Мөргөлдөөн гэх мэт
- 5 Бүс нутгийн аюулгүй байдлын нөхцөл байдал
- 6 Гэрээг батлах дотоодын шат дарааллыг түргэтгэх
 - 6.1 Засгийн газар ЗХЗГ-ний үүрэг одоо хэрэгжиж буй дотоодын тогтолцоо/хууль журамд нөлөөлөх нөлөөллийг үнэлэхэд цаг хугацаа шаардлагатай.
 - 6.2 Шаардлагатай дотоодын хуулийг бэлдэхэд цаг хугацаа орно.
 - 6.3 Яам хооронд, Засгийн газар болон парламент хоорондын сайн зохицуулалт зайлшгүй чухал.
 - 6.4 Төрийн албан хаагчийн томилгоо сэлгээ нь тус болохгүй.
- 7 Чадавхийг бий болгох нь
 - 7.1 Хүний нөөц болон мэргэжлийн мэдлэг (Гэрээг хэрэгжүүлэх).
 - 7.2 Санхүүгийн нөөц (санхүүгийн үүргийг биелүүлэх зорилго).
- 8 Илтгэх үүрэг
 - 8.1 Ерөнхийдөө ил тод хандахад хойрго байдаг. Илтгэх ажиллагаа нь нь хэт нарийвчилсан.
 - 8.2 Илтгэх зүйлс нь үндэсний аюулгүй байдалтай холбоотой эмзэг агуулга байдаг.
 - 8.3 Илтгэхээс ядарч залхдаг.
- 9 Бусад улс орнууд батлахыг хүлээдэг. Awaiting others to ratify (хөрш орнууд, гол экспортлогч болон импортлогч орнууд гэх мэт.).
- 10 ЗХЗГ-ний эх бичвэрийг оролцуулан, гэрээний зөвшилцлийн үр дүнгийн талаарх өөр өөр байр суурийг даван туулах
 - 10.1 Санал асуулгад суурилж гэрээг батлах
 - 10.2 Гэрээнд тусгай үүрэг байгаа эсэх

6. Түгээмэл асуудаг асуултууд

6.1 Энэ гэрээ нь олон улсын зэвсгийн худалдаанд ямар өөрчлөлт авчрах вэ?

Зэвсгийг шилжүүлэх шийдвэртэй холбоотой олон нийтийн санал дэвшүүлэх тогтолцоонд оролцогч улсууд ЗХЗГ-г дурдах тохиолдол улам бүр олширсоор байна. Үүнтэй адилаар, иргэний нийгэм болон хэвлэл мэдээлэл ч бас ЗХЗГ-ний заалтын үүднээс шилжүүлэх шийдвэрийг тайлбарлахыг шаардах тохиолдол нэмэгдэж байна. Тусгайлсан зэвсэг шилжүүлэх явдал нь хариуцлага хүлээсэн ажил мөн биш эсэхийн талаарх хяналтын явцад ЗХЗГ нь өнөөдөр бодитоор стандартын нэг хэсэг болж байна.

ЗХЗГ-ний иж бүрэн, бодитой үр нөлөөг дүгнэхэд хэт эртдэх боловч, зарим нэг оролцогч улс ЗХЗГ стандартад үндэслэн экспортыг хязгаарлаж байгаа бөгөөд зарим нэг оролцогч улсууд нь төрийн хувьд ийм үйлдлийг шаардах болсон томоохон шахалттай нүүр тулах болсон бодит баримтууд байна.

6.2 Гэрээнд хараахан нэгдэн ороогүй улсуудын хувьд ямар байдалтай байна вэ?

ЗХЗГ нь харьцангуй шинэхэн гэрээ юм. Гэсэн хэдий ч хүчин төгөлдөр болоод 4 гаруй жилийн хугацаанд аль хэдийнэ 100 давсан оролцогч улстай болж, ЗХЗГ -ний батлах / оролцох хурд нь зэвсэг бууруулах зорилготой ямар ч төрлийн гэрээнээс илүү хурдан байна.

Олон тооны улс орнууд гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд гэрээнд нэгдсэндээ тууштай хандлага үзүүлж ирсэн бөгөөд гэрээний үзэл санаа, зорилгод үл нийцэж болзошгүй үйлдлээс итгэл төгс сэргийлэхийг үүрэг болгож байгаа юм. (『Гэрээний хуулийн тухай Венийн хэлэлцээр』(Vienna convention on the Law of Treaties 1969) 10 ба 18-р зүйл)

Гэрээнд хараахан нэгдэн ороогүй байгаа олон улс орнууд оролцогч улс болохоор саналаа илэрхийлсэн бөгөөд гэрээнд нэгдэн орох шатанд явж байна. 2014 оны 12 дугаар сард гэрээ хүчин төгөлдөр болсноор гэрээнд гарын үсэг зурах явдал нь одоо бол сонголтын асуудал биш болжээ.

Гэрээний хэрэгжилт улам нэмэгдэж хангалттай тооны улс орон оролцогч болсон бөгөөд гэрээний нөхцлийг биелүүлснээрээ, мөн ЗХЗГ нь зэвсгийг “хариуцлагатай” шилжүүлэх тухай олон улсын стандартыг эмхлэн бий болгосноор гэрээний гишүүн бус орнууд ч хүртэл гэрээний зарчмыг дагах ёстой гэдэг шахалтыг мэдэрч байж болзошгүй юм.

6.3 Гэрээний хамрах хүрээ нь юу вэ?

ЗХЗГ нь тодорхой ангиллын бүх төрлийн ердийн зэвсгийн олон улсын шилжүүлэх үйл ажиллагааг зохицуулдаг.

6.3.1 ЗХЗГ нь ямар төрлийн зэвсэгт үйлчлэх вэ?

ЗХЗГ нь дараах жагсаалтад багтсан бүх төрлийн ердийн зэвсгийн талаарх олон улсын худалдааг зохицуулна. (2-р зүйлийн (1)-ийг харна уу).

1) Байлдааны танк;

- 2) Байлдааны хуягт машин;
- 3) Том калибрын артиллерийн систем;
- 4) Байлдааны онгоц;
- 5) Дайрагч нисдэг тэрэг;
- 6) Байлдааны хөлөг онгоц;
- 7) Пуужин болон пуужин хөөргөх төхөөрөмж
- 8) Буудлагын зэвсэг ба хөнгөн зэвсэг

ЗХЗГ нь дээр дурьдсан ердийн зэвсгээр галладаг, хөөргөдөг мөн зөөвөрлөдөг галт хэрэгслийн экспорт мөн түүнчлэн дээр дурьдсан ердийн зэвсгийг угсарч болох хэлбэрээр экспортлогдож байгаа эд анги, бүрэлдэхүүн хэсгийн экспортод ч бас үйлчилнэ. (3, 4-р зүйлийг харах)

6.3.2 ЗХЗГ-нд ямар төрлийн шилжүүлгүүд багтах вэ?

ЗХЗГ нь дараах төрлийн шилжүүлгүүдийг зохицуулна. (2-р зүйлийн (2)-г харах)

- экспортлох;
- импортлох;
- шилжүүлэх болон шилжүүлэн ачих мөн,
- зуучлах

Энэхүү гэрээ нь ердийн зэвсэг оролцогч улсын өмчлөлд байх нөхцөлд тухайн улс ашиглах зорилгоор оролцогч улсын, мөн оролцогч улсад зориулсан ердийн зэвсгийн олон улсын тээвэрт үйлчлэхгүй. (2-р зүйлийн 3-ыг харах)

Үүний дээр, ЗХЗГ нь “улс орнууд өөрийгөө батлан хамгаалах эрх, энхийг сахиулах үйл ажиллагааны төлөө ердийн зэвсгийг олж авах зохист эрхийг” нь хүлээн зөвшөөрдөг. (ЗХЗГ-ний зарчим 7-г харах)

6.4 Оролцогч улсууд амлалтаа дагаж мөрдөнө гэдэгт хэрхэн итгэх вэ?

ЗХЗГ-д заасан илтгэх шаардлага нь улс орнууд гэрээний дагуу амлалтаа биелүүлсэн эсэхийг хөөн нягтлахад тус болно. Бүх оролцогч улсууд гэрээний оролцогч болсноос 1 жилийн дотор гэрээг биелүүлэх хүчин чармайлтын талаарх анхны тайланг өгөх ёстой бөгөөд биелүүлэх арга хэмжээ шинээр хэрэгжүүлсэн тохиолдолд “шаардлагаас хамаарч тохиолдол бүрт” анхны тайланг шинэчлэх ёстой юм.

ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар нь гэрээнд тусгасан тусгай амлалтын талаарх оролцогч улсуудын биелүүлэлтийг архивладаг бөгөөд тэрхүү тусгай амлалтад ноогдох зардлын төлөлт, дотоодын хяналтын жагсаалтын талаарх мэдээллээр хангах (5-р зүйл), эрх бүхий төрийн байгууллага (5-р зүйл), улсын харилцаат байгууллага (13-р зүйл) болон анхны болон жилийн тайлан гаргах (13-р зүйл) гэх мэт багтана. Энэ мэдээлэл нь ЗХЗГ вебсайтаас ашиглаж болох боловч зарим нэг мэдээллийг зөвхөн оролцогч улсуудад л өгдөг.

Иргэний нийгэм мөн оролцогч улсууд гэрээний биелэлтийн талаарх амлалтыг хянах үүрэг хүлээдэг. Хэвлэл мэдээлэл ч бас оролцогч улсуудын гүйцэтгэсэн ЗХЗГ-ний амлалтын талаас улсын шилжүүлэх шийдвэрт бага багаар улам их асуудал дэвшүүлэх болсон.

ЗХЗГ-нд улс нэг бүрийн үр дүнг хянаж, биелүүлэлтийг түргэтгэхийн төлөөх албан ёсны үнэлгээний байгууллага(харилцан шалгах, мэргэжилтэн шалгах мөн хяналтын байгууллага гэх мэт) багтаагүй болно.

6.5 Гэрээний дагуу оролцогч улсын зэвсгийн импорт хориотой юу?

Зэвсэг шилжүүлэхийг зохицуулах олон улсын түвшний үүргийг зөрчих эсвэл шилжүүлсэн зэвсгийг аймаглан хороох, хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг мөн түүнчлэн дайны гэмт хэрэг явуулахад ашиглагдахыг оролцогч улс ухамсарлаж байсан бол ЗХЗГ-ний 6-р зүйлийн дагуу ердийн зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсэг, эд анги болон бүрэлдэхүүн хэсгийг шилжүүлэх(импортыг хамруулна)-ийг хориглоно. Тиймээс гэрээ нь оролцогч улс тодорхой нөхцөлд зэвсгийг импортлохоос сэргийлдэг мөн хориглодог. Мөн оролцогч улс тодорхой орчинд бусад улсруу экспортлохоос сэргийлнэ мөн хориглоно.

6-р зүйлийн дагуу ердийн зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсэг, мөн түүнчлэн эд анги болон бүрэлдэхүүн хэсгийн импорт болон шилжүүлэх нь хориотой биш боловч экспортлогч улс ЗХЗГ-ний оролцогч улс байх тохиолдолд тухайн зэвсэг эвсэл төрөл нь олон улсын хүмүүнлэгийн хууль юмуу олон улсын хүний эрхийн хуулийг ноцтойгоор зөрчих эсвэл зөрчлийг түргэтгэхэд ашиглагдах эрсдэл, экспортлогч улс оролцогч улс болох терроризмтой холбоотой олон улсын конвенци эсвэл хэлэлцээрт заасан гэмт хэргийг нөхцөлдүүлэх үйлдэл, мөн түүнчлэн экспортлогч улс нь гэрээний оролцогч болох үндэстэн дамнасан бүлэглэн гэмт хэрэгтэй холбоотой олон улсын конвенци болон хэлэлцээрт заасан гэмт хэргийг нөхцөлдүүлэх үйлдлийн тухай 7-р зүйлийн дагуу нэмэлт үнэлгээг гүйцэтгэх шаардлагатай. Экспортын харилцагч улс нь 7-р зүйлийн 1-т заасан ямарваа нэг зохисгүй үр дүнг учруулах “ноцтой эрсдэл” байна гэж үзсэн тохиолдолд экспортын оролцогч улс нь экспортыг зөвшөөрч болохгүй бөгөөд импортлогч улсын хүсч буй зэвсэг ба бүтээгдхүүнийг импортлохгүй болно. Экспортлогч улс нь ЗХЗГ-ний оролцогч улсын хувьд экспортын үнэлгээний үр дүнд “ноцтой эрсдэл” байна гэж дүгнэсэн бол импортлогч болон эцсийн хэрэглэгч нь хэн болохоос үл хамаарч экспортлохоос татгалзах ёстой.

Өөрөөр хэлбэл ЗХЗГ нь зэвсэг импортлогч улс эсвэл эцсийн хэрэглэгчээс хамаарч тодорхой хэлбэрээр ашиглагдах, ашиглагдаж болно гэж дүгнэсэн тохиолдолд ердийн зэвсгийг импортлож байгаа улсын чадавхид нөлөө үзүүлж болно. Гэвч импортлогч улс нь ЗХЗГ-ний оролцогч улс мөн биш гэхээс илүүтэй экспортлогч улс гэрээний оролцогч улс мөн эсэх, түүнчлэн 6 болон 7-р зүйлийн заалт үйлчлэх ёстой эсэхтэй илүү хамааралтай болно.

6.6 Иргэний нийгмийн байгууллагууд гэрээний хэрэгжитэд ямар үүрэг гүйцэтгэх вэ?

Иргэний нийгэм нь ЗХЗГ-ний түгээмэлжүүлэлт болон хэрэгжилтэд идэвхтэй оролцож байна. Иргэний нийгмийн байгууллагууд нь гэрээ нь улс төрийн хувьд нэн тэргүүнд тавигдах нөхцлөөр

хэрэгжих ёстой гэсэн олон нийтийн шахалтыг дамжуулах төдийгүй ЗХЗГ-ний түгээмэлжүүлэлт, хэрэгжүүлэлтийг дэмжиж байгаа бөгөөд мэдээллээ хуваалцаж хангах гэсэн зорилгын дагуу түгээмэлжүүлэлтийг дэмжихэд улс орны болон бүс нутгийн түвшинд зорьж буй үйл ажиллагаагаа тууштай хэрэгжүүлж байна. Иргэний нийгмийн үйл ажиллагаанд дараах зүйлс багтдаг.

- Тунхаглах болон батлахыг уриалахад хэрэг болох нөөц материал, танилцуулга, гарын авлага, компанит ажлын материал зэргийг бөгөөд гэрээг батлах болон нэгдэн орох гэж буй засгийн газарт техникийн мэргэжлийн мэдлэг болон зөвлөгөөг үзүүлэх
- Терроризм болж өөрчлөгдөхийг бууруулах гэх мэт зэвсгийг хянах тусгай хүрээний талаар бодлогын нөөц мөн бусад бүтэцтэй холбогдохыг хөгжүүлэх
- Холбогдох албан хаагч, мэргэжилтэн, ТББ-д зориулан техникийн туслалцаа, үр дүнтэй гэрээний хэрэгжилтийг дэмжихэд чиглэсэн бүс нутгийн семинар болон хурлыг дэмжих, зохион байгуулах
- Гэрээг батлах, хэрэгжүүлэх шат дарааллыг дэмжих судлаач болон эрдэмтдийн дунд сүлжээ үүсгэх
- Улс орнууд гэрээнд элсэх, үр дүнтэй хэрэгжүүлэх явцыг идэвхижүүлэх иргэдийн идэвхитэй оролцоог хангуулахын тулд таниулах үйл ажиллагааг дэмжих
- Гэрээний дагуу оролцогч улсуудын үүргийг хэрэгжүүлэх болон дагаж мөрдөх явцыг хянах